



БАЯНХОНГОР АЙМАГ
ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН СОНОМЫН ЛУВСАНВАНДАНГИЙН НЭРЭМЖИТ
ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 2/41

Номгон

Г С.Норовсамбуу, Б.Ууганбаяр, С.Энхтайван Г
нарыг оёдолчноор ажиллуулж Хөдөлмөрийн
түр гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 21.6, 23.2.2, 49.3 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. Ламын гэгээн Лувсанданзанжанцаны мэлмий гийсний 380 жилийн ойн Даншиг наадмын тоглолтын болон цаашид хэрэглэгдэх хөтлөгч, бүжигчдийн хувцасыг оёх оёдолчноор С.Норовсамбуу, Б.Ууганбаяр, С.Энхтайван нарыг томилж, Хөдөлмөрийн түр гэрээ байгуулсугай.

2. Оёдолчин С.Норовсамбууг ТҮСУ-2-5 дугаар шатлалаар 3 сар, Б.Ууганбаярыг ТҮСУ-2-1 дүгээр шатлалаар 2 сар, С.Энхтайваныг ТҮСУ-2-1 дүгээр шатлалаар 1 сарын хугацаатай 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дурьдсан хугацаанд тус тус цалинжуулахыг нягтлан бодогч Д.Ганхуягт зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын захиргаанаас олгосон материалыг зураачийн шийдэл, зураг скезийн дагуу чанарын өндөр түвшинд оёж, үйлдвэрлэлийн гологдолгүй гүйцэтгэхийг оёдолчин С.Норовсамбуу, Б.Ууганбаяр, С.Энхтайван нарт даалгасугай.

4. Оёдолчдын ажлын нөхцөл, ажлын байрыг бэлтгэж, товлосон хугацаанд өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг уран сайхны удирдагч, бүжгийн багш Ц.Алтанцэцэг, найруулагч С.Тогоомөнх нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ПҮРЭВДАГВА